ДУНДГОВЬ АЙМАГ
# ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 05 өдөр Дугаар А/55 Амардалай

**Газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаа явуулах тухай**

Монгол Улсын Засаг Захиргаа Нутаг Дэвсгэрийн Нэгж Түүний Удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, сумын 2021 оны “Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө”-г үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. Дуудлага худалдааны зарчмаар эзэмшүүлэх газрын хэмжээ, зориулалт байршил, хугацаа, дуудлага худалдааны анхны үнэ, дуудлага худалдаа явуулах өдрийг хавсралтаар баталсугай.

Хоёр. Дуудлага худалдааг цахим хэлбэрээр явуулж, дуудлага худалдааны зар мэдээг www.mle.mn газрын цахим биржид болон мэдээллийн хэрэгслээр олон нийтэд нээлттэй зарлан явуулсугай.

Гурав. Дуудлага худалдаа явуулах хугацаа, тавигдах шаардлага нөхцлүүдийг тодорхойлон олон нийтэд зарлан мэдэгдэж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг Газрын даамал /Л.Мөнхсарнай/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА М.БАЯРСҮХ

488010 156